



**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2019 оны 02 сарын 25 өдөр

Дугаар A/13

Улаанбаатар хот

Олон нийтийн цагдаагийн ажилтныг
ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, 25 дугаар зүйлийн 25.1, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, 9.2.1, Цагдаагийн албаны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах, зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий 4 /дөрвөн/ олон нийтийн цагдаагийн ажилтныг 1 жилийн хугацаанд ажиллуулсугай.

2. Олон нийтийн цагдаагийн ажилтны дүрэмт хувцас, цалингийн зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг дүүргийн Засаг дарга /Ж.Сандагсүрэн/, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Замын цагдаагийн хэлтсийн дарга /Г.Энхзориг/ нарт үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дэргэдэх Эрх зүй төрийн байгуулалтын хороо /Б.Мягмарсүрэн/-нд даалгасугай.

ДАРГА



Б.МӨНХЦЭЦЭГ